

# ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Гэрээ хэрэгжиж эхлэх өдөр: 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр

Энэхүү Хамтын ажиллагааны гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г дараах талуудын хооронд байгуулав:

1. Дорноговь аймгийн засаг дарга (цаашид “Аймаг” гэх);
2. Дорноговь аймгийн Улаанбадрах сумын засаг дарга (цаашид “Сум” гэх); болон
3. Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улс, Улаанбаатар хот, 1-р хороо, Жамъян Гүний гудамж 9, Ай Си Си Тауэр, 5-р давхарт албан хаягтай, улсын бүртгэлийн 5502977 дугаартай, Бадрах Энержи ХХК хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх).

Талуудыг цаашид дангаар нь “Тал”, хамтад нь “Талууд” гэнэ.

## Ерөнхий зүйл

(А) 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Орано Майнинг С.А.С. болон Компани нь Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулсан бөгөөд тус гэрээнд Хөрөнгө оруулалтын гэрээ болон хууль, тогтоомжид заасан нөхцөлөөр энэхүү Гэрээг байгуулж ажиллахаар заасан.

(Б) Компани нь Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Аргалант багийн нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд энэхүү гэрээний 2 дугаар Зүйлд дэлгэрэнгүй заасан, хууль тогтоомж болон Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд энэхүү Гэрээний үр өгөөжийг хүртэгч болох Аймаг болон Сумтай хамтран ажиллахыг эрмэлзэж байгаа.

Дээр заасныг тус тус харгалзан, харилцан хүлээсэн эрх, үүргүүдийнхээ хүрээнд Талууд ийнхүү дараахийг тохиролцов:

## 1. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

“**Авлигын эсрэг хууль**” гэж 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Монгол Улсын Авлигын эсрэг хууль, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг болон авлигын эсрэг олон улсын холбогдох хууль тогтоомжийг хэлнэ.

“**Ажлын өдрүүд**” гэж Бямба, Ням гараг, Монгол Улсад олон нийтээр амрах амралтын өдрүүдээс бусад өдрүүдийг хэлнэ.

“**АТГ**” гэж Монгол Улсын Авлигатай тэмцэх газрыг хэлнэ.

“**Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль**” гэж 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр батлагдсан Монгол Улсын Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

“**Ашигт малтмалын хууль**” гэж 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Монгол Улсын Ашигт малтмалын тухай хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

“**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль**” гэж 2012 оны 5 дугаар сарын 17-ний өдөр батлагдсан Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

“**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**” гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлд тодорхойлсон төлөвлөгөөг хэлнэ.

“**Байгаль орчны яам**” гэж Монгол Улсын Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамыг хэлнэ.

“**Бүтээн байгуулалтын үе шат**” гэж Хөрөнгө оруулалтын гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхэлж, дараалсан 60 (жар) хоногийн хугацаанд үйлдвэрлэлийн туршилт, тохируулгын зорилгоор үйлдвэрлэл явуулж, улсын комисс хүлээн авсан өдрөөр дуусгавар болох хугацааг хэлнэ.

“**Гамшиг**” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

“Гэрээ” гэж шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт оруулж болох энэхүү Гэрээ болон түүнд хавсаргасан бүх хавсралт бичиг баримтыг хэлнэ.

“Гэрээ хэрэгжиж эхлэх өдөр” гэж Талууд энэхүү Гэрээг байгуулж, гарын үсэг зурсан, Гэрээний эхний хэсэгт дурдсан огноог хэлнэ.

"Давагдашгүй хүчин зүйл" гэдэгт аль нэг Талын хяналтаас гадуур болсон, ямар нэг байдлаар урьдчилан таамаглах эсхүл урьдчилан сэргийлэх боломжгүй дараах үйл явдлын улмаас Гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор, заасан цаг хугацаанд биелүүлж чадахгүй болсныг буюу биелүүлэх хугацаагаа хэтрүүлснийг ойлгох боловч зөвхөн доорх тохиолдлуудаар хязгаарлагдахгүй:

- (a) газар хөдлөлт, үер, хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, гал түймэр, цас, зуд, хэмжээний бороо гэх мэт байгалийн бүх төрлийн гамшиг;
- (b) Монгол Улсын нутаг дэвсгэрт бий болсон дайн, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн ажиллагаа, бослого, хорлон сүйтгэх ажиллагаа;
- (c) Засгийн газраас тогтоосон бүх төрлийн нийтийг хамарсан хязгаарлалт, хорио, цээр, өвчин тахал;
- (d) нийт ажилчдыг хамарсан ажил хаялт, бүслэлт, суулт;
- (e) Монгол Улсын хилийн боомтуудыг хаах, худалдааны хориг тавигдах, тээвэрлэлтийн хязгаарлалт;
- (f) Компанийн үйл ажиллагааг аливаа төрийн байгууллага эсхүл нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрээр түдгэлзүүлэн зогсоосон; мөн
- (g) Компанийн Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн эсхүл хүчингүй болгосон.

“Дэмжлэг” гэж энэхүү Гэрээний дагуу Төслүүдийг хэрэгжүүлэхэд Компаниас төсөвлөсөн санхүүгийн болон бусад дэмжлэг, туслалцааг хэлнэ.

“Ёс зүйн дүрэм” гэж Компанийн “Бидний ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм”-ийг хэлнэ.

“Жилийн төлөвлөгөө” гэж энэхүү Гэрээний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх Төслүүдэд холбогдох зорилго, цар хүрээ, төсөв, хэрэгжилтийн хугацаа, Талуудын үүрэг, үр нөлөө ба өгөөж зэргээс бүрдсэн Төслийн тодорхойлолт, жагсаалтыг агуулсан баримт бичгийг хэлнэ.

“Засаг дарга” гэж Аймаг болон/эсхүл Сумын Засаг даргыг хэлнэ.

“Засаг даргын тамгын газар” гэж Аймаг, Сумын Засаг дарга, тэдгээрийн удирдлага дор үйл ажиллагаа явуулж буй холбогдох тамгын газруудыг хэлнэ.

**"Засгийн газар"** гэж Монгол Улсын засгийн газар, түүний харьяа яам, агентлаг, алба, хэлтсүүдийг хэлнэ.

**"Иргэдийн төлөөлөгчдийн хурал"** эсхүл **"ИТХ"** гэж Аймаг, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг хэлнэ.

**"Орон нутгийн компани"** гэж Аймаг, Сумын нутаг дэвсгэрт бараа, материал үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй бизнесийн байгууллага, аж ахуйн нэгжийг хэлнэ.

**"Орон нутгийн иргэд"** гэж Аймаг, Сумын нутаг дэвсгэрт албан ёсоор бүртгэлтэй ажиллаж, амьдарч буй хүмүүсийг хэлнэ.

**"Орд ашиглах гэрээ"** гэж гэж Ашигт малтмал, газрын тосны газар болон Төсөл хэрэгжүүлэгч компани нарын хооронд 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Орд ашиглах шинэчилсэн гэрээг хэлэх бөгөөд тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбарыг хэлнэ.

**"Ивээн тэтгэх"** гэж Компанийн болон түүний Хамаарал бүхий этгээдүүдийн сурталчилгаа болон брэнд хөгжүүлэлтийн холбоотой хэрэгжүүлж буй олон нийттэй харилцах стратегийн нэг хэсэг болох ивээн тэтгэх үйл ажиллагааг хэлнэ.

**"Техник эдийн засгийн үндэслэл"** эсхүл **"ТЭЗҮ"** гэж Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 074 дугаар тушаал болон тухай бүр шинэчилсэн тушаал болон бусад баримт бичигт тодорхойлсны дагуу Улсын бүртгэлд бүртгэгдсэн нөөцийн эдийн засгийн хэсэгт тулгуурлан ашигт малтмалыг олборлох, боловсруулах төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн техник технологийн сонголт, инженерийн шийдэл, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хүний нөөц, удирдлага зохион байгуулалт, дэд бүтэц, хангамж, нийгэм, ахуй үйлчилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцоо болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон зураг, тооцоолол, тайлбар бүхий техникийн цогц баримт бичиг, түүний тодотголыг хэлнэ.

**"Төсвийн тухай хууль"** гэж 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Монгол Улсын Төсвийн тухай хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

**"Тусгай зөвшөөрөл"** гэж Компанийн эзэмшиж буй цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын гурван тусгай зөвшөөрөл (MV-018914, MV-018915, MV-018916 дугаартай) болон аливаа шинээр Компанид олгогдох ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хэлнэ.

**"Төслүүд"** гэж энэ Гэрээний 2 болон 4 дүгээр зүйлд заасан чиглэлүүдийн хүрээнд Компанийн санхүүгийн болон бусад дэмжлэгээр Аймаг болон Сумын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагдсан төслүүдийг хэлнэ.

"**Хамаарал бүхий этгээд**" гэж аль нэг Талын хувьд тухайн Талыг шууд болон шууд бусаар Хянадаг, эсхүл тухайн Тал нь өөрөө шууд болон шууд бусаар Хянагддаг, эсхүл тухайн Талын хамт нэгдсэн Хяналт дор байдаг аливаа компани, нөхөрлөл, корпорац, холбоо болон бусад хуулийн этгээдийг хэлэх бөгөөд тухайн Талын охин компани эсхүл толгой компани мөн хамаарна. "Хянах" болон "Хяналт" гэдэгт тухайн хуулийн этгээдийн саналын эрхийн 50 (тавь) болон түүнээс дээш хувийг шууд, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан шууд бусаар эзэмшихийг ойлгоно.

"**Ханган нийлүүлэгчид**" гэж Компани (эсхүл түүний Хамаарал бүхий этгээд)-тай гэрээ байгуулж, Төслүүдтэй холбоотой аливаа үйл ажиллагаа явуулж буй, ханган нийлүүлэлт хийж, үйлчилгээ үзүүлж буй компани эсхүл хувь хүнийг хэлнэ.

"**Хамтын ажиллагааны хороо**" гэж энэхүү Гэрээний 8 дугаар Зүйлд заасан хороог.

"**Холбогдох хууль тогтоомж**" гэж Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам, тушаал, үндэсний акт, норм, стандартуудыг хэлнэ.

"**Хөрөнгө оруулалтын гэрээ**" гэж 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Орано Майнинг С.А.С. болон Компани хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээг хэлэх бөгөөд тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбарыг хэлнэ.

"**Хөрөнгө оруулалтын тухай хууль**" гэж 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

"**Хуанлийн жил**" гэж тухайн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хамрах хугацааг хэлнэ.

"**Шилэн дансны тухай хууль**" гэж 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

"**Эрүүгийн хууль**" гэж 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийг, түүнд орсон болон цаашид орох аливаа нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг хэлнэ.

## **2. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО**

Энэхүү Гэрээ нь дараах зорилготой:

Хөрөнгө оруулалтын гэрээний 11.1(b)-д заасны дагуу Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан чиглэл болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нээлттэй ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг даах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж асуудлыг шийдвэрлэх, тухайн бүс нутагт иргэд ажиллаж амьдрахад тулгамдаж буй болон нэн шаардлагатай байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөн хандив, тусламж үзүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих асуудлыг зохицуулах.

## **3. САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛБЭРҮҮД**

3.1. Хөрөнгө оруулалтын гэрээний 11.1(c)-д заасны дагуу Аймаг, Суманд орон нутгийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, зохион байгуулахад Компани нь хамтын ажиллагааны дараахь чиглэлээр Дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- (a) орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, боловсрол, эрүүл мэнд, соёл болон дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх;
- (b) орон нутагт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх;
- (c) Компани үйл ажиллагаагаа явуулж буй бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх;
- (d) иргэдийн итгэлцлийг нэмэгдүүлж, төсөл хэрэгжих явцад ил тод байдлыг хангах; болон
- (e) хандив тусламж, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх замаар Дорноговь аймаг, Улаанбадрах сумын иргэдийн амьжиргааг дээшлүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжих.

3.2. Компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд ба энэхүү Гэрээний цар хүрээнд хамруулахгүйгээр санхүү, эд материалын тусламж дэмжлэгийг өөрийн дотоод дүрэм журамд нийцүүлэн үзүүлж болох бөгөөд гэхдээ заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.

3.3. Төслүүдэд дараах орохгүй. Үүнд:

- (a) соёл, урлаг, спортын арга хэмжээнд оруулах дэмжлэг,
- (b) Ивээн тэтгэх шинжтэй дэмжлэгүүд,
- (c) аливаа хувь хүн, гэр бүлд зориулсан хандив, тусламж, эсхүл ивээн тэтгэлэг.

#### **4. ТӨСЛҮҮД БОЛОН ДЭМЖЛЭГ**

- 4.1. Хамтын ажиллагааны хороогоор хэлэлцэж, дэмжсэн Төслүүдийг, энэхүү Гэрээнд заасан санхүүжилтийн хэлбэр, зорилго, хугацаа, үнийн дүнд нийцсэн санхүүгийн болон бусад дэмжлэгээр Аймаг болон Суманд хэрэгжүүлнэ.
- 4.2. Хөрөнгө оруулалтын гэрээний 11.2(a)-д заасны дагуу Компанийн жил тутамд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд зарцуулах Дэмжлэгийн хэмжээ нь татварын дараах цэвэр дүнгээр Бүтээн байгуулалтын үе шатанд 300,000 (гурван зуун мянган) ам.доллар байна. Тухайн жилийн хувьд мөрдөх ам.доллар – төгрөгийн ханш нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр Монголбанкны зарласан албан ханш байна.
- 4.3. Тухайн жилийн Дэмжлэгийн дүнг эцсийн байдлаар хэрхэн Аймаг, Суманд хуваарилах тухай шийдвэрийг Аймаг, Сум хамтран шийдвэрлэх бөгөөд албажуулсан шийдвэрийг Гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс хойш 30 хоногийн дотор Компанид бичгээр мэдэгдэнэ.
- 4.4. Талууд Дэмжлэгийг Гэрээний бүх нөхцөл, болзолыг биелүүлсний үндсэн дээр тухайн Хуанлийн жилд багтаан бүрэн ашиглах талаар бүх талын хүчин чармайлт гаргаж ажиллана. Хуанлийн жилийн ашиглагдаагүй Дэмжлэгийн үлдэгдлийг дараагийн Хуанлийн жилийн Дэмжлэгт шилжүүлж, нэмж тооцно. Жишээлбэл, хэрэв 2026 он дуусахад 100,000 ам.доллар ашиглагдаагүй үлдсэн тохиолдолд уг дүнг 2027 оны Дэмжлэгийн үнийн дүн рүү шилжүүлж, нэмж тооцох бөгөөд ингэснээр 2027 оны Дэмжлэгийн нийт дүн 400,000 ам.доллар (2027 оны 300,000 + 2026 оны үлдэгдэл 100,000 = 400,000) болно.
- 4.5. Хөрөнгө оруулалтын гэрээний 11.1(e)-д заасны дагуу Компани нь Төслүүдийг дэмжихдээ үр нөлөө, өгөөжийг үндсэн шалгуур болгон санхүүжүүлэх бөгөөд Төслүүд нь энэхүү Гэрээний 2 дугаар Зүйлд дэлгэрэнгүй заасан зорилтууд, хамрах хүрээний шаардлагыг хангасан байна.
- 4.6. Тухайн жилд энэхүү Гэрээний дагуу санхүүжүүлж хэрэгжүүлэх Төслүүдийг Жилийн төлөвлөгөөнд тусгах бөгөөд тус төлөвлөгөөг Талууд энэхүү Гэрээний 8.5-д зааснаар санал нэгтгэйгээр батлана. Санал болгосон Төслүүдийг сонгож, Жилийн төлөвлөгөөнд тусгахдаа дараах зарчмуудыг баримтлана:
- Гэрээний 2, 3 дугаар зүйлд заасан зорилго, санхүүжилтийн хэлбэрт нийцсэн байх;
  - Хөрөнгө оруулалтын гэрээний 11.1(e)-д заасны дагуу, үр нөлөө, өгөөжийг нь үндсэн шалгуур болгон эрэмбэлж үнэлгээ хийсэн байх;
  - энэхүү Гэрээний 8.1(b)-д заасан, Хамтын ажиллагааны хороогоор баталсан урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцсэн байх;
  - судалгаа, шинжилгээнд үндэслэгдсэн байх; мөн

- бодитоор хэрэгжүүлэх боломжтой байх.

- 4.7. Гэрээтэй холбоотойгоор үүссэн авлига, хээл хахуулийн, бизнесийн ёс зүйг зөрчсөн, эсхүл Төслүүдийг хэрэгжүүлэхэд Дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан тухай аливаа тохиолдол бий болсон эсхүл үндэслэл бүхий гомдол гарсан бол Компани Дэмжлэгийг буцаах, зогсоох эсхүл түдгэлзүүлэх шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд, зогсоохоор шийдвэрлэсэн Төсөлд зориулан зарцуулсан холбогдох Дэмжлэгийн дүнг дараагийн жилийн Дэмжлэгийн үнийн дүнд шилжүүлж, нэмж тооцохгүй.

## **5. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

### **5.1. Авлигаас урьдчилан сэргийлэх, Ил тод байдлыг эрхэмлэх**

Авлигын эсрэг хууль, Шилэн дансны тухай хууль, Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хөрөнгө оруулалтын гэрээ болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтаа Талууд биелүүлж ажиллана. Хөрөнгө оруулалтын гэрээний 13 дугаар зүйл (*Авлигаас урьдчилан сэргийлэх*) нь Талууд болон Гэрээний үүргээ гүйцэтгэхэд нэгэн адил (*mutatis mutandis*) үйлчлэхийг Талууд хүлээн зөвшөөрсөн болно.

### **5.2. Хамтын ажиллагааны хороо байгуулах**

Талууд энэхүү Гэрээнд заасан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, зохион байгуулах зорилгоор Хамтын ажиллагааны хороог байгуулна.

### **5.3. Жилийн төлөвлөгөөг батлах**

Энэхүү Гэрээний дагуу тухайн жилд санхүүжүүлж, хэрэгжүүлэх Төслүүд бүхий Жилийн төлөвлөгөөг Талууд санал нэгтгэйгээр, энэхүү Гэрээний 8.5-д зааснаар батална.

## **6. АЙМАГ, СУМ, БА ТЭДГЭЭРИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **6.1. Гэрээний дагуу Аймаг, Сумын Засаг дарга нар дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:**

6.1.1. Энэхүү Гэрээний дагуу хэрэгжүүлэх Компаниас санхүүжүүлсэн Төслүүдийн Аймаг, Сумын иргэдэд өгөх үр өгөөжийг ханган ажиллах;

6.1.2. Компанийн Үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулахад хууль тогтоомжийн хүрээнд бодитой дэмжиж ажиллах;

6.1.3. Компаниас Бүтээн байгуулалтын үе шатанд хэрэгжүүлэх ажлыг Хөрөнгө оруулалтын гэрээ болон хууль тогтоомжид нийцүүлэн дэмжиж ажиллана;

6.1.4. Энэхүү Гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгаж, Орон нутгийн иргэдийг тогтмол хугацаанд энэхүү Гэрээнд холбогдох мэдээллээр хангах, Компаниас холбогдох мэдээллээ өгч ажиллахыг шаардах;

- 6.1.5. Компанитай хамтран энэхүү Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх Төслүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах;
- 6.1.6. Хамтын ажиллагааны хорооны хүрээнд Гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтын биелэлтийг хангуулах; мөн
- 6.1.7. Компанийн зүгээс холбогдох хууль тогтоомжийн дагуу тавьсан хүсэлт, шаардлагыг авч хэлэлцэн, холбогдох хууль тогтоомжид тусгасан цаг хугацаанд багтаан зохих хариуг хүргүүлж, дэмжлэг туслалцааг тухай бүр үзүүлэх.

## **7. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 7.1. Гэрээний дагуу, Хөрөнгө оруулалтын гэрээ болон хууль тогтоомжид нийцүүлэн, Компани дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
  - 7.1.1. Энэхүү Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх Төслүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийх бөгөөд хэлэлцүүлгийг өмнөх жилийн дөрөвдүгээр улиралд зохион байгуулна.
  - 7.1.2. Хөрөнгө оруулалтын гэрээний 11.1(g)-д заасны дагуу Компани нь санхүүгийн жил дууссанаас хойш 30 (гуч) хоногийн дотор энэхүү Гэрээний хүрээнд сонгогдсон Төслүүдтэй холбогдуулан хийж гүйцэтгэсэн ажил болон эдгээр Төслүүдийн хэрэгжилтийн талаарх жилийн тайланг Гэрээний талуудад хүргүүлж, олон нийтэд ил тод мэдээлнэ.
  - 7.1.3. Гэрээний хүрээнд хэрэгжүүлэхээр санал болгосон аль нэг төсөл нь Холбогдох хууль тогтоомж, Хөрөнгө оруулалтын гэрээнд нийцээгүй, мөн Компанийн холбогдох дотоод дүрэм журам, үүнд зайлшгүй дагаж мөрддөг авлига, мөнгө угаалтын эсрэг эсхүл нийцлийн шаардлагыг хангаагүй тохиолдолд Компани хэрэгжүүлэхээс татгалзах эрхтэй.
  - 7.1.4. Компани урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, 8.1(b)-д заасны дагуу Хамтын ажиллагааны хороонд батлуулахаар хүргүүлнэ.
  - 7.1.5. Энд заасан аливаа заалт нь, Компанийн үзэж байгаагаар, энэхүү Гэрээ эсхүл Компанийн үйл ажиллагаанд хууль бусаар хөндлөнгөөс оролцсон, эсхүл нөлөөлсөн этгээд, нөхцөл байдалтай холбоотой аливаа асуудлаар Авлигатай тэмцэх газар болон/эсхүл бусад хууль сахиулах байгууллагад хандах Компанийн эрхийг хязгаарлаж, эсхүл хориглохгүй.
  - 7.1.6. Энэхүү Гэрээнд зохицуулаагүй асуудал, тухайлбал орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, худалдан авалт болон байгаль орчны асуудлыг Хөрөнгө оруулалтын гэрээ болон/эсхүл Орд ашиглах гэрээгээр зохицуулна.

## 8. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

### 8.1. Чиг үүрэг:

Хамтын ажиллагааны хорооны чиг үүрэгт дараах багтана. Үүнд:

- (a) Талууд хоорондын ажлын нааштай харилцааг дэмжиж, урагшлуулах;
- (b) Компанийн боловсруулсан урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, батлах, чингэхдээ урт хугацааны тогтвортой хөгжлийн бодлогод чиглүүлэх, хууль эрх зүйн нийцлийн үнэлгээ хийх, судалгаа, бодлого зохицуулалтын гэх мэт дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- (c) Сонирхогч талуудаас Төслүүдэд ирүүлсэн саналуудыг хэлэлцэж, Жилийн төлөвлөгөөний төслийг гаргаж, дор 8.5-д зааснаар Талуудаар хянуулж, Хамтын ажиллагааны хорооны хурлаар эцэслэн батлуулахаар хүргүүлнэ;
- (d) Батлагдсан Жилийн төлөвлөгөөнд тусгасан Төслүүдийн хэрэгжилт болон гүйцэтгэсэн ажлын талаарх жилийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө боловсруулж гарган, тайланг олон нийтэд танилцуулах ажлыг хийхэд, Аймаг, Сум, Багийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан зэрэгт танилцуулахад Компанид шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- (e) Гэрээгээр хэрэгжүүлэх Төслүүдтэй холбоотой гарсан санал, гомдлыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлэх;
- (f) Төслүүдийн гүйцэтгэлийг хянаж, үнэлж, дүгнэж, өбатлагдсан Төслүүдийн төлөвлөлт, хэрэгжилт, удирдан зохион байгуулалт, хяналтын үйл ажиллагаануудтай холбоотой мэдээллийг Хамтын ажиллагааны хорооны хуралд болон Аймаг, Сум, багуудын ИТХ-ийн хурлуудад танилцуулах; мөн
- (g) Гэрээний хэрэгжилтийн талаар Талуудад зөвлөмж өгөх.

8.2. Хамтын ажиллагааны хорооны хүсэлтээр, Хамтын ажиллагааны хорооны хэвийн үйл ажиллагаанд шаардлагатай сургалт, зөвлөх үйлчилгээ, туршлага солилцох уулзалт зэрэг дэмжлэг туслалцааг Компани өөрийн бүрэн үзэмжээр хариуцан зохион байгуулж болох ба гэхдээ заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй бөгөөд энэ тохиолдолд холбогдох зардлыг Компани хариуцах ба энэ нь Дэмжлэгийн төсвөөс гарахгүй.

### 8.3. Хамтын ажиллагааны хорооны бүрэлдэхүүн:

8.3.1. Хамтын ажиллагааны хороо нь нийт саналын эрхтэй есөн (9) гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллана. Үүнд:

- Аймгийн Засаг даргын тамгын газраас 3 гишүүн,
- Сумын Засаг даргын тамгын газраас 2 гишүүн,

- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 1 гишүүн, мөн
- Компаниас 3 гишүүн тус тус багтана.

Тал бүр Хамтын ажиллагааны хорооны нарийн бичгийн даргад бичгээр (имэйлээр) мэдэгдэл хүргүүлснээр өөрийн гишүүнээ хэдийд ч өөрийн шийдвэрээр чөлөөлж, шинээр томилж болно.

- 8.3.2. Хамтын ажиллагааны хорооны хуралд Аймаг, Суманд бүртгэлтэй Орон нутгийн иргэд, Орон нутгийн компани болон байгууллага, мөн Компани эсхүл түүний Хамаарал бүхий этгээдийн ажилтнууд ажиглагчаар оролцож болно. Ажиглагчид саналын эрхгүй оролцоно.
- 8.3.3. Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, Хамтын ажиллагааны хорооны гишүүд нь энэхүү Гэрээнд ямар нэг нэмэлт өөрчлөлт оруулах, эрх үүргээс татгалзах эрх мэдэлгүй болно.
- 8.3.4. Хамтын ажиллагааны хорооны даргыг гишүүдийн олонхийн саналаар хоёр (2) хүртэлх жилийн бүрэн эрхийн хугацаатайгаар сонгох бөгөөд дараах үүрэгтэй байна. Үүнд:
  - (a) Хамтын ажиллагааны хорооны хурал тус бүрийг удирдан явуулах, мөн
  - (b) Олон нийтийн арга хэмжээнүүдэд Хамтын ажиллагааны хороог төлөөлөн оролцох.
- 8.3.5. Хамтын ажиллагааны хорооны даргын эзгүйд орлох этгээдийг Хамтын ажиллагааны хорооны гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
- 8.3.6. Хамтын ажиллагааны хорооны нарийн бичгийн даргыг Компанийн зүгээс томилох бөгөөд тэрээр хурлын тэмдэглэл хөтлөх, Хамтын ажиллагааны хорооны дотоод ажлын засаглал, удирдлагыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээнэ. Шаардлагатай тохиолдолд Компани нь Зөвлөлийн дотоод үйл ажиллагааг удирдан зохион байгуулах болон Нарийн бичгийн даргын үүргийг мэргэжлийн гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд холбогдох бүх зардлыг Компани хариуцна.

#### 8.4. Хамтын ажиллагааны хорооны хурал:

- 8.4.1. Хамтын ажиллагааны хороо жилд дөрвөн (4) удаа ээлжит байдлаар хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнээс дээш удаа хуралдаж болно.
- 8.4.2. Хамтын ажиллагааны хорооны хуралд тав (5) болон түүнээс дээш гишүүн оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд үүнд Компанийн хамгийн багадаа нэг гишүүн заавал багтсан байна.

- 8.4.3. Дор 8.5 дугаар Зүйлд дэлгэрэнгүй заасан Жилийн төлөвлөгөөг батлах тухай шийдвэрээс бусад Хамтын ажиллагааны хорооны бүх шийдвэрийг Хамтын ажиллагааны хорооны хуралд оролцож буй саналын эрх бүхий гишүүдийн олонхын саналаар батлана. Гишүүн тус бүр саналын нэг (1) эрхтэй байна.
- 8.4.4. Аль нэг гишүүн нь бусдын өмнөөс аливаа үүрэг амлалт, төлөөлөл, баталгаа, эсхүл гэрээ хийх эрхгүй бөгөөд гишүүн бүр өөрт нь ийм эрх олгогдоогүй болохыг хүлээн зөвшөөрнө.
- 8.4.5. Хамтын ажиллагааны хорооны хурлыг биечлэн эсхүл утас, видео хурал зэрэг харилцаа холбооны хэрэгсэл ашиглан зохион байгуулж болно. Биечлэн зохион байгуулах тохиолдолд хурлыг Аймгийн төв эсхүл Улаанбаатар хотод хуралдуулна.
- 8.4.6. Компанийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөл болон дотоод дүрэм журамд нийцүүлэн, Хамтын ажиллагааны хорооны хурлыг зохион байгуулахтай холбоотой зардал (хурлын танхим болон бусад зардал), мөн Хамтын ажиллагааны хорооны хуралд оролцох гишүүд, ажиглагчдын зардал (тээвэр, байр, хоол)-ыг Компани хариуцах бөгөөд энэхүү зардлыг тухайн жилийн Дэмжлэгийн төсөвт оруулж тооцохгүй. Компаниас олгох аливаа зардлын нөхөн төлбөр нь гагцхүү зөвхөн үндэслэл бүхий, баримтаар нотлогдсон зардлаар хязгаарлагдах бөгөөд үүнийг Компанийн албан томилолт, аяллыг зохицуулсан дотоод дүрэм журам, мөн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтооно. Хөрөнгө оруулалтын гэрээний 13.3(а)-ийн заалтад чанд нийцүүлэн, нийтийн албан тушаалтан, төрийн албан хаагч болох Хамтын ажиллагааны хорооны гишүүнд Компаниас дээр зааснаар олгосон зөвшөөрөгдсөн зардлын нөхөн төлбөрийн мэдээлэл нь нээлттэй байх бөгөөд олон нийтэд нээлттэй тавигдана.
- 8.4.7. Хамтын ажиллагааны хорооны хурлаар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан аль нэг гишүүн ашиг сонирхлын зөрчилтэй (**“Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн”**) байвал:
- тухайн Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн өөрөө ашиг сонирхлын зөрчлөө мэдэгдэх, эсхүл өөр гишүүн уг нөхцөл байдлын талаар мэдэж байвал ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх; мөн
  - Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн тухайн асуудлаар санал хураалтад оролцохгүй байх шаардлагатай.

Хэрэв ашиг сонирхлын зөрчлөө мэдэгдээгүй бөгөөд тухайн асуудал санал хураалтаар дэмжигдсэн бол ашиг сонирхлын зөрчил илэрсэн дараагийн Хамтын ажиллагааны хорооны хуралдаанаар уг асуудлыг Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүний оролцоо, саналыг тооцохгүйгээр дахин хэлэлцэнэ.

## 8.5. Жилийн төлөвлөгөөг батлах:

- 8.5.1. Хамтын ажиллагааны хороо нь, энэхүү Гэрээний 4.6 дах Зүйлд заасан зарчмуудад үндэслэн сонгож санал болгосон Төслүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий дараа жилийн Жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, Талуудаар хянуулахаар хүргүүлнэ.
- 8.5.2. Хамтын ажиллагааны хорооны бэлдсэн Жилийн төлөвлөгөөний төслийг хүлээн авсны дараа Талууд тус төслийг өөрсдийн холбогдох дотоод дүрэм журамд нийцүүлэн хянаж, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн, зөвшөөрөх эсхүл эс зөвшөөрөх тухай шийдвэрээ Хамтын ажиллагааны хорооны нарийн бичгийн даргад бичгээр хуанлийн 30 хоногийн дотор мэдэгдэнэ. Хэрэв энэ хугацаанд аль нэг Тал Хамтын ажиллагааны хороонд хариу хүргүүлээгүй бол тухайн Тал Жилийн төлөвлөгөөний төслийг бүхэлд нь зөвшөөрсөнд тооцно.
- 8.5.3. Жилийн төлөвлөгөөний төслийг Талууд хянаж дууссанаар Хамтын ажиллагааны хороо нь гагцхүү Талууд бүгд зөвшөөрсөн Төслүүдийг багтаасан Жилийн төлөвлөгөөний шинэчилсэн төслийг боловсруулж, Хамтын ажиллагааны хорооны хурлаар эцэслэн батлуулахаар бэлтгэнэ.
- 8.5.4. Дараа жилийн Жилийн төлөвлөгөөний шинэчилсэн төслийг Хамтын ажиллагааны хорооны гишүүдээр эцэслэн батлуулахаар Хамтын ажиллагааны хорооны өмнөх жилийн 4 дүгээр улирлын ээлжит хуралд танилцуулна. Жилийн төлөвлөгөөг хуралд оролцож буй саналын эрх бүхий Хамтын ажиллагааны хорооны бүх гишүүд санал нэгтгэйгээр батлана. Гишүүн тус бүр саналын нэг (1) эрхтэй байна.

## 9. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

### 9.1. Маргааны хэлэлцээр

Энэхүү Гэрээтэй холбоотойгоор, эсхүл түүнээс үүдэн, үүнд гэрээг дуусгавар болгох эсхүл хүчингүй болгохтой холбоотойгоор, Талуудын хооронд эсхүл аль нэг Талын хооронд, энэхүү Гэрээнд холбогдох аливаа шаардлага, маргаан, саналын зөрүү эсхүл зөрчил (цаашид “**Маргаан**” гэх) гарсан тохиолдолд аль нэг Тал нөгөө Талдаа тухайн Маргааны талаар бичгээр мэдэгдэл (цаашид “**Маргааны талаарх мэдэгдэл**” гэх) хүргүүлж болно. Талуудын эрх бүхий төлөөлөгчид шударгаар хэлэлцээ хийж, харилцан зөвшилцөх замаар Маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Талуудын эрх бүхий төлөөлөгчид тухайн Маргааныг хуанлийн 180 (нэг зуун наян) хоногийн дотор шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

- 9.2. Дээрх 9.1 дүгээр Зүйлд заасны дагуу шийдвэрлэгдээгүй аливаа Маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

- 9.3. Талууд өөрөөр тохиролцоогүй эсхүл аливаа шүүх, арбитрын шүүхээс өөрөөр тогтоогоогүй бол, хууль эрх зүйн болон бусад мэргэжлийн туслалцааны зардлаас бусад Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бүх өртөг зардлыг Маргаанд ялагдсан Тал нь хариуцна.
- 9.4. Энэхүү 9 дүгээр Зүйлийн заалтууд Гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд болон Гэрээ дуусгавар болсны дараа, эсхүл хугацаанаасаа өмнө дуусгавар болсон тохиолдолд Гэрээтэй холбоотой, эсхүл түүнээс үүдэн гарсан аливаа Маргааныг шийдвэрлэхэд үйлчилнэ.
- 9.5. Талууд Маргаантай холбоотойгоор олон нийтэд аливаа мэдэгдэл хийхийг хатуу хориглоно.

## **10. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА БОЛОН ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ**

### **10.1. Гэрээний хугацаа:**

Энэхүү Гэрээ нь Гэрээ хэрэгжиж эхлэх өдрөөс эхлэн Бүтээн байгуулалтын үе шат дуусах хүртэлх хугацаанд бүрэн хүчин төгөлдөр хэрэгжиж, хүчинтэй үйлчилнэ. Гэхдээ дараах тохиолдолд энэхүү Гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно: i) Талуудын бичгээр байгуулсан тохиролцооны дагуу, эсхүл ii) Хөрөнгө оруулалтын гэрээ дуусгавар болсон.

### **10.2. Гэрээг дуусгавар болгох:**

10.2.1. Хэрэв аль нэг Тал нөгөө Талыг энэхүү Гэрээний үндсэн үүрэг (тухайлбал энэхүү Гэрээний 5 болон 8 дугаар Зүйлд заасан үүрэг)-ийн аль нэгийг ноцтой зөрчсөн гэж шударгаар үзсэн тохиолдолд тус Тал нөгөө Талдаа уг зөрчлийг хуанлийн ерэн (90) хоногийн дотор арилгах тухай бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.

10.2.2. Хэрэв уг зөрчлийг дээрх 10.2.1 дүгээр Зүйлд заасан хугацааны дотор арилгаагүй бол зөрчил гаргаагүй Тал нь зөрчил гаргасан Талд бичгээр мэдэгдэл хүргүүлсэнээр энэхүү Гэрээг цуцалж болно, гэхдээ энэ нь энэхүү Гэрээний 9 дүгээр Зүйлд заасан маргаан шийдвэрлүүлэх эрхийг хөндөхгүй.

## **11. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ ТОХИОЛДСОН ҮЕД ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

Аль нэг Тал Давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн үйл явдлын улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ бүхэлд нь эсхүл хэсэгчлэн биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд (i) тухайн Давагдашгүй хүчин зүйлийг арилгахын тулд боломжийн хүчин чармайлт гаргах; (ii) Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон эсхүл түүнд өртсөнөө мэдсэнээс хойш арван дөрвөн (14) хоногийн дотор нөгөө Талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлд тухайн нөхцөл байдал, түүнийг засч залруулахад шаардагдах зүйлс (засч залруулах боломжтой бол), даван туулахад шаардагдах

хугацааны тооцоолол, мөн уг нөхцөл байдлын улмаас цаг хугацаанд нь бүрэн дүүрэн биелүүлж чадахгүй байгаа гэрээний үүргүүдийг тодорхой тусгах; (iii) ийм нөхцөл байдал үргэлжилж байх хугацаанд тухайн Талыг гэрээний үүргээ биелүүлээгүй гэж үзэхгүй бөгөөд үүргүүдийг түдгэлзүүлсэнд тооцно.

## **12. ТАТВАР**

Компани нь, Гэрээний дагуу төлөх аливаа төлбөр (аливаа Дэмжлэгийг оролцуулан)-т эсхүл төлбөрт холбогдуулан, Хуулийн дагуу аливаа татвар (татвар, хураамж, суутгал гэх мэт)-ын суутгал хийх шаардлагатай бол Компани тухайн суутган төлөх татварыг хариуцна. Энэхүү Гэрээнд заасан Дэмжлэгийн үнийн дүнд татварын суутгалыг оруулж тооцохгүй бөгөөд Дэмжлэгийн дүнг бүрэн хэмжээнд зарцуулна.

## **13. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

Гэрээнд зөвхөн бичгээр, бүх Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурснаар нэмэлт өөрчлөлт оруулж болно. Тус нэмэлт өөрчлөлт нь Гэрээний салшгүй нэг хэсэгт тооцогдоно.

## **14. ЭРХ, ҮҮРЭГ ШИЛЖҮҮЛЭХ**

### **14.1. Компанийн зүгээс эрх, үүрэг шилжүүлэх**

Компани Гэрээнд тусгасан бүхий л (бүрэн хэмжээгээр) эрх, ашиг сонирхлоо өөрийн Хамаарал бүхий этгээд, аливаа гуравдагч талд шилжүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд тухайн Хамаарал бүхий этгээд, гуравдагч тал Компанийн Гэрээний бүхий л үүргийг хариуцан хүлээхээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг биелүүлэх чадвар, чадамжтай байна. Эрх шилжүүлэн авагч этгээд болон Засаг дарга нар нэг бүрийн хооронд шинээр гэрээ байгуулсан даруйд тухайн эрх шилжүүлэн авагч этгээдийн эдлэх эрх, хүлээх үүргийн цар хүрээ, хэмжээгээр Компани Гэрээний үүрэг, хариуцлагаасаа чөлөөлөгдөнө.

### **14.2. Аймаг, Сум эрх, үүрэг шилжүүлэх эрхгүй байх**

Аймаг, Сум нь Гэрээгээр хүлээсэн эрх, үүргүүдээ бусдад даалгах буюу шилжүүлэх эрхгүй байна.

## **15. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ**

### **15.1. Талууд шийдвэр, мэдэгдэл, хүсэлт, шаардлага, зөвшөөрөл, баталгаа зэрэг бүхий л мэдэгдэл, харилцаагаа бичгээр үйлдэн, биечлэн эсхүл баталгаат шуудан, цахим хэлбэрээр нөгөө Талдаа дараахь хаягаар хүргүүлнэ.**

Компанид хүргүүлэх бол:

Хүлээн авагч этгээд:

Хаяг:

Гүйцэтгэх захирал

Бадрах Энержи ХХК-ийн албан оффис

Монгол Улс, Улаанбаатар хот, 1-р хороо,

Жамъян Гүний гудамж-9

Ай Си Си Тауэр, 5-р давхар

coralie.prin@orano.group

Аймгийн Засаг даргад хүргүүлэх бол:

Хүлээн авагч этгээд:

Хаяг:

Имэйл хаяг:

Аймгийн Засаг дарга

Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар

zdtg@dornogovi.gov.mn

Сумын Засаг даргад хүргүүлэх бол:

Хүлээн авагч этгээд:

Хаяг:

Сумын Засаг дарга

Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар

- 15.2. Компанийн албан хаяг өөрчлөгдвөл Компани таван (5) Ажлын өдөрт багтаан Засаг дарга нарт мэдэгдэнэ.

**16. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА**

Тал тус бүр дараахийг мэдэгдэж, батлав.

(a) Талууд энэхүү Гэрээг байгуулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан.

(b) Энэхүү Гэрээ нь хүчин төгөлдөр бөгөөд Гэрээнд тусгасан нөхцөлүүдийн дагуу Талууд заавал биелүүлэх үүрэг хүлээж, хэрэгжүүлнэ.

**17. ГЭРЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДАЛ**

- 17.1. Гэрээ болон түүнд дурдсан бичиг баримтууд нь Гэрээгээр зохицуулсан асуудлын хувьд Талуудын бүрэн дүүрэн тохиролцоо бөгөөд Гэрээнд өөрөөр заагаагүй бол Талуудын хоорондын өмнөх бүхий л хэлцэл, тохиролцоо, ойлголтыг орлоно. Гэрээний бүх хавсралт нь Гэрээнд дурдсанаар энэхүү Гэрээний нэг хэсэгт тооцогдоно.

- 17.2. Гэрээг Англи, Монгол хэл дээр тус бүр дөрвөн (4) адил хувь, нийт 8 хувь үйлдэв.

**ГЭРЭЭГ БАТАЛЖ, ГАРЫН ҮСЭГ ЗУРСАН:**

ДОРНОГОВЬ АЙМГИЙГ ТӨЛӨӨЛЖ  
ЗАСАГ ДАРГА

О.БАТЖАРГАЛ

УЛААНБАДРАХ СУМЫГ ТӨЛӨӨЛЖ  
ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБҮРЭН

КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ  
БАДРАХ ЭНЕРЖИ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

КОРАЛИ ПРИН